

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА**

2023.12.28

Булган аймаг

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй


Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3б хавсралтын дагуу гаргасан тайланд бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцох аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2023 онд Булган аймагт 16 зорилтын 19 арга хэмжээг хариуцуулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д байршуулсныг хяналтад авч, хэрэгжилтийг үнэлэв.

2023 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 91.1 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Энэ нь эхний хагас жилийн үнэлгээтэй харьцуулахад 25.5 пунктээр нэмэгдсэн байна. Эдийн засгийн бодлогын 5 зорилтын



6 арга хэмжээ 78.3 хувь, засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээ 96.7 хувь, ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээ 100 хувь, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээ 96.7 хувьтай тус тус хэрэгжлээ. Үүнээс 12 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90.0 хувь, 2 арга хэмжээ 70.0 хувь, 1 арга хэмжээ 30.0 хувийн хэрэгжилттэй гарлаа. Харин 1 арга хэмжээ аймагт хамааралгүй байна.

Тус төлөвлөгөөнөөс төсөв хөрөнгөгүйгээс шалтгаалан хэрэгжилт нь удааширч байгаа 1 арга хэмжээг 30.0 хувиар дүгнэлээ. Үүнд:

- 3.3.9.2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.

Харин “4.3.11.2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.” арга хэмжээ манай аймагт хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай байна.

Гурав. Дүгнэлт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар тооцож, үнэлэн дараах дүгнэлтийг хийв.

- 2023 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.
- Арга хэмжээнүүдийн 94.4 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байгаагаас шалгаалан зарим ажил удаашралтай хэрэгжиж байна.
- Засгийн газраас аймагт хариуцуулсан арга хэмжээнүүд дунд манай аймагт хамааралгүй заалт байгааг хяналтаас хасуулах саналтай байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс аймагт хамаарах арга хэмжээ бүрийг жигд ханган зохион байгуулж, явцын болон гүйцэтгэлийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцох
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах

- Сумын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлаг, байгууллагууд үйл явцыг бус гүйцэтгэл, үр дүн, хүрсэн түвшний талаар тайлагнаж, тухайн арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тусгаж тайлагнах

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС